



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/01/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор **Ц.Наранчимэг**

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер **С.Оюунгэрэл**

Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор **Ш.Ичинхорлоо**

Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор **О.Баярмаа**

Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Улаанбаатар хот
2019 он

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
3.1.	Орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар	9
3.1.1.	Илрүүлэлт	9
3.1.2.	Эрсдэл	9
3.1.3.	Зөвлөмж	9
3.1.4.	Байгууллагаас өгсөн хариу тайлбар	9
3.2.	Авлагын талаар	10
3.2.1.	Илрүүлэлт	10
3.2.2.	Эрсдэл	10
3.2.3.	Зөвлөмж	10
3.2.4.	Зөвлөмж	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ЧИНБАТ ТАНАА

2019.03.25 № 06/555
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн орлогын төвлөрүүлэлт болон авлага үүсгэн бүртгэх асуудлыг шийдвэрлэх талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 19-нөөс 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 01/199 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам,

түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох зорилгоор төрийн бодлогын хүрээнд мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хамгийн түгээмэл үйлчилгээг тухайн хүн амын байршил, амьжиргааны түвшингээс үл хамааран бодит үнээр хүргэх, алслагдсан орон нутагт зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх, сүлжээг шинээр барьж байгуулах, өргөтгөх, үйлчилгээ явуулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны зорилтууд дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хөдөлгөөнт холбооны чиглэлээр 3,
- Харилцаа холбооны чиглэлээр 2,
- Интернетийн үйлчилгээг хүргэх чиглэлээр 1,
- Радио, телевизийн үйлчилгээний чиглэлээр 1,
- Шуудангийн чиглэлээр 1,
- Судалгаа, сурталчилгааны чиглэлээр 7, нийт 15 төсөл хэрэгжүүлсэн байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

- Харилцаа холбооны тухай хууль
- Шуудангийн тухай хууль
- Радио долгионы тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөх үе шатанд Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгож, нийт зардлын 1 хувь буюу 45.2 сая төгрөгөөр материаллаг түвшинг тогтоосныг гүйцэтгэх үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцсон болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	63.1	
	Дүн	2	63.1	

2.8.1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан ба бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Тайлант онд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 15 төсөл хөтөлбөрт зориулан 2,347.5 сая, хөрөнгө оруулалтад 500.0 сая, урсгал зардалд 152.5 сая, нийт 3,000.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,861.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын гүйцэтгэлээр 138.2 сая төгрөг буюу 4.6 хувьтай хэмнэгдсэн байгаа нь төсөл сонгон шалгаруулалтын үр дүнд төслийн төсөвт өртөг буурснаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 239.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгөгдсөнөөс хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар

3.1.1. Илрүүлэлт

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 520 байгууллагаас улсын төсөвт 3,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,936.9 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 63.1 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

3.1.2. Эрсдэл

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, МТШХХГ-ын даргын 2013 оны 107 дугаар тушаалаар батлагдсан БНҮҮС-ийн үйл ажиллагааны дүрмийн 8.1-д “МТШХХГ-нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.3. Зөвлөмж

Батлагдсан төлөвлөгөөний дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас санд төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллагын холбогдох ажилтнууд асуудлын бүртгэлтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн.

3.2. Авлагын талаар

3.2.1. Илрүүлэлт

Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд нь албан татвар ногдуулах орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийн тайлангаа дараа оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлж, төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцуулдаг боловч тус сан нь тайлант оны 3-р улирлын санхүүгийн тайланг үндэслэн тооцоолж авлага үүсгэн бүртгэж байна.

3.2.2. Эрсдэл

Энэ нь жилийн эцсийн баталгаажуулсан тайлангаас санд төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцоход бүртгэсэн авлагын дүн буурах, зарим аж ахуйн нэгж байгууллага алдагдалтай ажиллах зэрэг нь үндэслэлгүйгээр авлагын хэмжээг өсгөх эрсдэлтэй байна.

3.2.3. Зөвлөмж

Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийн жилийн эцсийн баталгаажуулсан тайлангаас санд төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцож, авлага үүсгэх

3.2.4. Зөвлөмж

Тус байгууллагын холбогдох ажилтнууд асуудлын бүртгэлтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн.

Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,316,108,203.35	10,825,347,903.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,975,001.01	43,574,734.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,975,001.01	43,574,734.51
3121	Төгрөг	9,975,001.01	43,574,734.51
31211	Төрийн сангийн харилцах	9,975,001.01	43,574,734.51
33	АВЛАГА	2,073,531,938.34	973,698,590.45
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,192,445,987.20	00.00
335	Бусад авлага	881,085,951.14	973,698,590.45
3351	Байгууллагаас авах авлага	881,085,951.14	973,698,590.45
35	БАРАА МАТЕРИАЛ	8,232,601,264.00	9,808,074,579.00
351	Түүхий эд материал	8,232,601,264.00	9,808,074,579.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	8,232,601,264.00	9,808,074,579.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,296,661.96	19,469,395.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,296,661.96	19,469,395.89
392	Биет хөрөнгө	19,588,328.77	17,075,666.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,600,000.00	34,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,677,618.98	-24,135,723.88
39205	Машин тоног төхөөрөмж	24,517,543.31	10,709,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,278,953.53	-5,803,069.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,732,563.54	9,607,985.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,305,205.57	-7,902,725.81
393	Биет бус хөрөнгө	708,333.19	2,393,729.26
39301	Програм хангамж	4,150,000.00	5,131,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,441,666.81	-2,738,020.74
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,336,404,865.31	10,844,817,299.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,972,538.60	46,623,057.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,972,538.60	46,623,057.60
413	Өглөг	11,972,538.60	46,623,057.60
4136	Бусад өглөг	11,972,538.60	46,623,057.60
41361	Байгууллагад төлөх өглөг	11,887,962.60	46,623,057.60
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	84,576.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,324,432,326.71	10,798,194,242.25
51	Засгийн газрын хувь оролцоо	10,324,432,326.71	10,798,194,242.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	15,761,977,619.52	15,761,977,619.52
51101	Өмч: - төрийн	15,761,977,619.52	15,761,977,619.52
512	Хуримтлагдсан үр дүн	-5,445,147,412.46	-4,971,385,496.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-7,201,566,578.40	-6,364,196,962.46
51220	Тайлант үеийн үр дүн	1,756,419,165.94	1,392,811,465.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,602,119.65	7,602,119.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,336,404,865.31	10,844,817,299.85

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,151,546,360.99	5,915,747,981.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,098,633,953.52	3,205,638,192.35
120	Нийтлэг татварын бус орлого	2,098,633,953.52	3,205,638,192.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,098,633,953.52	3,205,638,192.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,082,981,572.52	3,204,608,192.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,030,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,652,381.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,052,912,407.47	2,710,109,789.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,052,912,407.47	2,710,109,789.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,052,912,407.47	2,255,264,515.50
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	454,845,274.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,386,520,060.99	4,522,936,516.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,386,520,060.99	4,522,936,516.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,120,787.61	393,596,852.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,758,285.47	110,039,000.00
210101	Үндсэн цалин	100,440,185.47	102,053,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,318,100.00	7,986,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,853,500.00	13,204,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,853,500.00	13,204,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,977,500.00	12,007,500.00
210401	Бичиг хэрэг	1,823,750.00	2,707,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,372,000.00	5,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,851.38	958,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, зүйлс	2,400,898.62	2,741,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,929,992.00	3,150,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,929,992.00	3,150,200.00
2107	Томилолт, зочны зардал	7,070,500.00	7,611,000.00
210702	Дотоод албан томилолт	6,390,500.00	6,621,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	680,000.00	989,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	816,430.00	1,273,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,600.00	83,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,189,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,714,580.14	246,311,202.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,070,000.00	216,722,286.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,821,500.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,823,080.14	6,238,916.07
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	23,350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,088,399,273.38	4,129,339,664.24
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,088,399,273.38	4,129,339,664.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,088,399,273.38	4,129,339,664.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,765,026,300.00	1,392,811,465.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,607,134.06	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,607,134.06	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-8,607,134.06	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,756,419,165.94	1,392,811,465.54

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	-290,151,568.40	15,479,428,170.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			6,911,415,010.00	-6,911,415,010.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	7,201,566,578.40	8,568,013,160.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			1,756,419,165.94	1,756,419,165.94
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	5,445,147,412.46	10,324,432,326.71
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	5,445,147,412.46	10,324,432,326.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-919,049,550.00	-919,049,550.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	6,364,196,962.46	9,405,382,776.71
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			1,392,811,465.54	1,392,811,465.54
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	4,971,385,496.92	10,798,194,242.25

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>4,288,644,580.85</u>	<u>7,460,643,603.24</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,235,647,597.38	3,089,590,977.04
120	Нийтлэг татварын бус орлого	2,235,647,597.38	3,089,590,977.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,235,647,597.38	3,089,590,977.04
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,235,647,597.38	3,088,560,977.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,030,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,052,996,983.47	4,371,052,626.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,052,912,407.47	4,371,034,677.20
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,052,912,407.47	2,347,503,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	454,845,274.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	376,155,640.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00.00	1,192,530,563.20
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	84,576.00	17,949.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	84,576.00	17,949.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,288,644,580.85</u>	<u>6,972,198,595.74</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,200,245,307.47	2,750,517,722.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,227,707.47	152,697,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,758,285.47	110,039,000.00
210101	Үндсэн цалин	100,440,185.47	102,053,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,318,100.00	7,986,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,853,500.00	13,204,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,853,500.00	13,204,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,977,500.00	12,007,500.00
210401	Бичиг хэрэг	1,823,750.00	2,707,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,372,000.00	5,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,851.38	958,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,898.62	2,741,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,929,992.00	5,930,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,929,992.00	5,930,100.00
2107	Томилолт, зочны зардал	7,070,500.00	7,611,000.00
210702	Дотоод албан томилолт	6,390,500.00	6,621,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	680,000.00	989,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	816,430.00	3,905,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,600.00	83,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,821,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,821,500.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,821,500.00	00.00
212	ТАТААС	2,053,017,600.00	2,597,820,422.00

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,053,017,600.00	2,597,820,422.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,053,017,600.00	2,597,820,422.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,088,399,273.38	4,221,680,873.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	102,525.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	102,525.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,088,399,273.38	4,221,578,348.74
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	92,238,684.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,088,399,273.38	2,936,893,677.04
213306	Улсын төсвийн орлогод тооцож төвлөрүүлэх	00.00	1,192,445,987.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	488,445,007.50
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	-454,845,274.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	454,845,274.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	454,845,274.00
220001	Барилга байгууламж	00.00	454,845,274.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	33,599,733.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,975,001.01	9,975,001.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,975,001.01	43,574,734.51

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,000,000,000.00	2,861,777,089.50	-38,222,910.50	95.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,500,000,000.00	2,406,931,815.50	-93,068,184.50	96.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	152,496,800.00	151,667,300.00	-829,500.00	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,039,000.00	110,039,000.00	-	100.0
Үндсэн цалин	102,053,000.00	102,053,000.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	7,986,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,204,700.00	13,204,700.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	13,204,700.00	13,204,700.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	10,977,500.00	10,977,500.00	-	100.0
Бичиг хэрэг	1,871,100.00	1,677,700.00	-193,400.00	89.7
Тээвэр, шатахуун	5,205,800.00	5,600,000.00	394,200.00	107.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,600.00	958,500.00	-962,100.00	49.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	1,980,000.00	2,741,300.00	761,300.00	138.4
Эд хогшил, урсгал засварын зардал	5,930,100.00	5,930,100.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	5,930,100.00	5,930,100.00	-	100.0
Томилолт, зочны зардал	7,611,000.00	7,611,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	6,353,700.00	6,621,350.00	267,650.00	104.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	989,650.00	-267,650.00	78.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,734,500.00	3,905,000.00	-829,500.00	82.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,000.00		-495,000.00	
Даатгалын үйлчилгээ	198,000.00		-198,000.00	
Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	83,500.00	-114,500.00	42.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00		-22,000.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,821,500.00	3,821,500.00	-	100.0
ТАТААС	2,347,503,200.00	2,255,264,515.50	-92,238,684.50	96.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,347,503,200.00	2,255,264,515.50	-92,238,684.50	96.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,347,503,200.00	2,255,264,515.50	-92,238,684.50	96.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000,000.00	454,845,274.00	-45,154,726.00	91.0
Барилга байгууламж	500,000,000.00	454,845,274.00	-45,154,726.00	91.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,000,000,000.00	2,861,777,089.50	-38,222,910.50	95.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,847,503,200.00	2,710,109,789.50	-37,393,410.50	95.2
Улсын төсвөөс санхүүжих	2,847,503,200.00	2,710,109,789.50	-37,393,410.50	95.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,496,800.00	151,667,300.00	-829,500.00	99.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,496,800.00	150,637,300.00	-1,859,500.00	98.8

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,030,000.00	1,030,000.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
Төсвийн байгууллага /ЗГТС/	1	1		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11	-	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	10	10	-	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11	11	-	
Гэрээт ажилтан	11	11	-	

5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/1/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан		мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 520 байгууллагаас улсын төсөвт 3,000,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,936,893.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 63,106.3 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар дутуу төвлөрүүлсэн,	63,106.3	Зөвлөмж өгсөн	БНҮҮС-ийн дарга, нягтлан бодогч	Ч.Цогтгэрэл Т.Халиунаа
2	Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд нь албан татвар ногдуулах орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийн тайлангаа дараа оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлж, төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцуулдаг боловч тус сан нь тайлант оны 3-р улирлын санхүүгийн тайланг үндэслэн тооцоолж авлага үүсгэн бүртгэсэн байна.	-	Зөвлөмж өгсөн	БНҮҮС-ийн дарга, нягтлан бодогч	Ч.Цогтгэрэл Т.Халиунаа
	Дүн	63,106.3			

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс